ХЭНТИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

Эрүүл мэндийн газрын байр, Сариг баг,
Хэрлэн сум, Хэнтий аймаг, 23119
Утас: 7056 2553, Цахим хуудас: mohs.khe.gov.mn
Цахим шуудан: eruulmendgazar@khe.monhs.gov.mn

2024.05.14 № 10-34-02/127/11

“ТӨГС ГРАНД КОНСТРАКШН” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ П.УНДАРМАА-Д

Барилгын зураг төсөлд хяналт
хийсэн тухай

“Төгс гранд констракшн” ийн боловсруулсан барилгын ажлын зурагт Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг үндэслэн Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газртын даргын баталсан 10-00/02 дугаартай удирдамжийн дагуу Хэнтий аймгийн Галшар сумын 160 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн өргөтгөлийн барилгын зураг төсөлд эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийлээ.

Нэг. Барилга байгууламжийн зориулалт:

Хэнтий аймгийн Галшар сумын 160 хүүхдийн хүчин чадалтай сургуулийн өргөтгөлийн барилга нь тэнхлэгээрээ 38х19м хэмжээтэй, төмөр бетон каркасан бүтээцтэй. Цэвэр, бохир, дулаан хангамж нь төвлөрсөн системээс хангагдахаар төлөвлөгдсөн байна. 1 дүгээр давхартаа хичээллэх анги, гал тогоо, хооллох заал байрлана. 2 дугаар давхартаа урлаг заал, номын сан, хичээллэх өрөөтэй. Урлаг зааланд дуу тусгаарлагч акустик хавтан хийхээр төлөвлөсөн байна.

Зургийн ЕГ Шифр ТГ-23/012

Хоёр. Захиалагчийн нэр, хэзээ, хаана баригдах:

Хэнтий аймгийн ЗДТГ-ын захиалгаар өргөтгөлийн ажил хийгдэнэ. Ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг “Төгс гранд констракшн” ХХК-ийн архитектур Э.Должинсүрэн боловсруулж, захирал П.Ундармаа гарын үсэг зурсан. Зургийн ЕГ Шифр ТГ-23/012

Гурав: Инженер геологийн судалгааны талаар:

Тус барилгын инженер-геологийн судалгааг “Төгс гранд констракшн” ХХК-ийн захиалга, даалгаварыг үндэслэн харилцан тохиролцсоны дагуу “Ленд тест” ХХК гүйцэтгэн архив №22/205, ЗТ11-753/18 тоот дүгнэлтийг гаргасан байна.

Дөрөв: Дүгнэлт

Тус барилгын ажлын зураг нь Олон нийт иргэний барилга БНбД 31-03-03 болон бусад аюулгүйн техникийн норм, стандартын шаардлагыг хангасан байна. Зураг төсөлд өөрчлөлт оруулах шаардлага гарвал Эрүүл мэндийн газрын холбогдох улсын байцаагчид мэдэгдэх шаардлагатай.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:
ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Г.БУЖМАА

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:
“ТӨГС ГРАНД КОНСТРАКШН” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ П.УНДАРМАА

ТӨГС ГРАНД КОНСТРАКШН ХХК
6063721 1116220917
УЛААНБААТАР ХОТ

340000

# ХЭНТИЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
# ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МАГАДЛАЛ ХИЙСЭН ТУХАЙ ДҮГНЭЛТ

2024 оны 05 сарын 02 өдөр Дугаар 60/04 Чингис хот

"ТӨГС ГРАНД КОНСТРАКШН" ХХК-Д

**Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл**

1. Барилга байгууламжийн байршил: Хэнтий аймаг Галшар сумын 6 дугаар баг "160 хүүхдийн сургуулийн өргөтгөл"-ийн барилгын ТГ-23/012 шифрын дугаартай зураг төсөл.

2. Зураг төслийн компани: "ТӨГС ГРАНД КОНСТРАКШН" ХХК Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг, 13-р хороо, Өнөр хороолол 8-378 тоот

3. Барилга байгууламжийн зориулалт: Хэнтий аймаг Галшар сум 6 дугаар баг "160 хүүхдийн сургуулийн өргөтгөл"-ийн барилгын ажлын зураг, аймгийн ерөнхий архитектурын АТД-23-033/23 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавартай.

4. Барилга байгууламжийн давхар, талбай: Ерөнхиий боловсролын сургуулийн зориулалттай 2 давхар, тэнхэлгээрээ 38x19 хэмжээтэй 4946,58 м3 барилга юм.

5. Галд тэсвэршилтийн зэрэг: 1

6. Барилгын үүргийн галын аюулын анги: Ф1.1,

7. Зургийн иж бүрдэл: 11 хэсэг, 216 хуудас

**Хоёр. Барилга байгууламжийн зураг төслийн галын аюулгүй байдал**

1. **Үүргийн галын аюулын Ф1.1 анги:** "Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт" /БНбД 31-25-22/, Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт /ЗГ-ын 2023 оны 98 дугаар тогтоол/ барилга угсралтын үед баримтлан ажиллах.

**Гурав. Ерөнхий дүгнэлт**

"ТӨГС ГРАНД КОНСТРАКШН" ХХК-ийн боловсруулсан Хэнтий аймаг Галшар сум 6-р баг сумын "160 хүүхдийн сургуулийн өргөтгөл"-ийн ТГ-23/012 шифрын дугаартай ажлын зураг төсөлд Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах магадлал хийх дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3 дах хэсэгт заасны дагуу дүгнэлт гаргав.

Барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

| Хянасан сар, өдөр | Тэмдэг дарсан хуудасны дугаарууд | Нэмэлт тэмдэглэл |
| --- | --- | --- |
| 2024.05.02 | БА-4, 5, 10, 20, 22, 23, 24, 26, 27, ХАС-9, 10, 11, 14, ЦБУ-7, ДГ-3, 4, ХТ-16, 17, 18, 20, 23, ХД-7, 8, ГЦ-9, | Барилгын ажлыг зураг төслийн дүгнэлтийн дагуу гүйцэтгэх. |

ДҮГНЭЛТ ГАРГАСАН.
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ,
ХОШУУЧ Ө.ГАНЗОРИГ